



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/201

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчөөс төрийн өмчид
эд хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Нийслэлийн Онцгой байдлын газрын балансад бүртгэлтэй, 110,339,500 (нэг зуун арван сая гурван зуун гучин есөн мянга таван зуу) төгрөгийн, Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй, 29,736,434 (хорин есөн сая долоон зуун гучин зургаан мянга дөрвөн зуун гучин дөрөв) төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгслүүдийг энэ захирамжийн хавсралтад зааснаар төрийн өмчид шилжүүлсүгэй.

2.Хавсралтад заасан тээврийн хэрэгслийг төрийн өмчид шилжүүлэх ажлыг зохион байгуулж, данс бүртгэлээсээ хасахыг нийслэлийн Онцгой байдлын газар (А.Дашням), Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв (Д.Энхбаатар)-д зөвшөөрсүгэй.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



1110201109

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
 03 дугаар сарын 20 ны өдрийн
 захирамжийн хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

№	Эд хөрөнгийн нэр	Марк	Улсын дугаар	Арлын дугаар	Ашиглалтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл (2022.09.30)	Үлдэх өртөг	Дахин үнэлсэн үнэ	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	Тусгай албаны бүхээгтэй машин	Дун фэн	66-31 УБП	LGAXBH1 M7736056 47	2009	42,000,000	42,000,000	0	8,400,000	Нийслэлийн Онцгой байдлын газар	Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газар
2	Бага оврын автобус	Старекс	25-41 УНК	KMJWSH7 JP9U1493 76	2016	11,089,500	8,871,600	2,217,900			Дундговь аймгийн Онцгой байдлын газар
3	Автобус	Хьюндай каунти	87-42 УНЧ	KM93H5M FD6KB2J0 02	2018	12,250,000	9,800,000	2,450,000			Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Ар тал хангалтын 115 дугаар анги
4	Туулах чадвар сайтай автомашин	Инфинити	00-47 УБН	JN8AZ2N E2B90073 21	2020	45,000,000	15,000,000	30,000,000		Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв	Хэнтий аймгийн Баянхутаг сумын Эрүүл мэндийн төв
5	Дунд оврын автомашин	УАЗ 3962	13-43 БРА	220695H0 404080	2017	29,736,434	22,853,000,32	6,883,433,68			
Шилжүүлэх хөрөнгийн нийт дүн						140,075,934	75,671,600	34,667,900	8,400,000		